



Цаг үе, үйл явдал

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит "Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор" тэмцээн гурван өдрийн туршид амжилттай явагдаж өчигдөр өндөрлөлөө. Тэмцээний хаалтын ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл, тэмцээнийг шүүсэн шүүгчдийн бүрэлдэхүүн, хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнууд оролцсон юм.

Тэмцээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах 12 байгууллагын 800 гаруй алба хаагчид "Байнгын бүрэлдэхүүний салаа", "Хугацаат цэргийн алба хаагчдын салаа", "Эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг", "Рот" гэсэн төрлөөр мэргэжлийн ур чадвар, тэсвэр хатуужил, эр зоригоо сорин өрсөлдсөн юм.

Энэ жилийн тэмцээний "Рот"-д зөвхөн Зэвсэгт хүчнийхэн оролцсоноос тэргүүн байрт хошууч генерал Б.Амгаланбаатар командлагч, ахмад Б.Ариунболд (016) захирагчтай Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын рот 0:48:55.53 амжилтаар, дэд байрт бригадын генерал Б.Баатар командлагч, цэрэгжлийн спортын мастер, ахмад Б.Цэвэроров (350) захирагчтай Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын рот 0:49:16.73 амжилтаар, гутгаар байрт дэслэгч генерал Д.Ганзориг дарга, цэрэгжлийн спортын мастер, ахмад С.Алтангэрэл (310) захирагчтай Зэвсэгт хүчний Жанжин штабын рот 1:24:12.43 амжилтаар тус тус шалгарлаа. ЗХЖШ-ын ротод Зэвсэгт хүчний 013, 310, 311 дугаар ангиудаас шалгарсан тамирчин дайчид багтаж, дасгалжуулагчаар Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн ахлагч, тэргүүн ахлагч Б.Лхагвабаатар, ХЗЦК-ын ротод Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 119, 186, 256, 326 дугаар ангийн шилдэг алба хаагчид багтаж, дасгалжуулагчаар ХЗЦК-ын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн Биеийн тамир, спортын офицер, дэд хурандаа С.Энхтайван, ТХЦК-ын ротод Зэвсэгт хүчний 150, 330, 350 дугаар ангийн шилдэг тамирчин дайчид багтаж, дасгалжуулагчаар Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, хошууч Э.Амартүвшин нар ажилласан юм. Байнгын бүрэлдэхүүний салаагаар Зэвсэгт хүчин, ХХЕГ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, ТТХГ, Дотоодын цэргийн штаб, ШШГЕГ гэсэн найман байгууллагын шилдэг алба хаагчид мэргэжлийн ур чадвар, тэсвэр хатуужил, эр зоригоо сорин өрсөлдөж, аваргуудаа тодруулахад

тэргүүн байрт дэслэгч генерал Д.Ганзориг дарга, ахлах дэслэгч М.Цэрэнням захирагчтай ЗХЖШ-ын байнгын бүрэлдэхүүний салаа 0:27:51.61 амжилтаар, дэд байрт хошууч генерал Г.Ариунбуян дарга, дэслэгч А.Нямбаяр захирагчтай ОБЕГ-ын байнгын бүрэлдэхүүний салаа 0:48:51.66 амжилтаар, гутгаар байрт хурандаа Р.Чингис дарга, дэслэгч Б.Бумбаяр захирагчтай Дотоодын цэргийн штабын байнгын бүрэлдэхүүний салааны дайчид 0:55:35.90 амжилтаар шалгарч, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг нараас шагналаа гардан авсан юм. Тэгвэл "Хугацаат цэргийн алба хаагчдын салаа"-ны төрөлд ЗХЖШ, ХЗЦК, Дотоодын цэргийн штаб, ҮБХИС, ДХИС гэсэн таван байгууллага оролцсоноос тэргүүн байрт дэслэгч генерал Д.Ганзориг дарга, ахлах дэслэгч Б.Цэнгэлсүрэн захирагчтай ЗХЖШ-ын хугацаат цэргийн алба хаагчдын салаа 0:39:54.27 амжилтаар, дэд байрт бригадын генерал П.Жаргалан захирал, ахмад Т.Бямбацогт захирагчтай ҮБХИС-ийн сонсогч нарын салаа 0:44:20.61 амжилтаар, гутгаар байрт хошууч генерал Б.Амгаланбаатар командлагч, дэслэгч Л.Мөнхбат захирагчтай Хуурай замын цэргийн командлалын хугацаат цэргийн алба хаагчдын салаа 1:08:24.42 амжилтаар хошуучлан манлайлав.

Дээрх салааны дасгалжуулагчаар дэд хурандаа Г.Дүнжингарав, дэд хурандаа Ж.Батсайхан, ахмад З.Өнөрбек нар ажилласан юм. Мянга мянган дайчдаасаа шалгаран энэхүү тэмцээнд оролцож, бүр тэргүүлж байгаа явдалд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх онцгойлон баяр хүргэж байв.

Төгсгөлд нь онцлох тамирчид бол эмэгтэй цэргийн алба хаагчид юм. Энэ жил Зэвсэгт хүчин, ЦЕГ, ШШГЕГ, ТЕГ, ХХЕГ, ОБЕГ, ҮБХИС, ДХИС, Дотоод цэргийн штаб гэсэн 9 байгууллагын эмэгтэй цэргийн алба хаагчид тасгаар оролцож, ур чадвараа сорин өрсөлдөхөд тэргүүн байрт дэслэгч генерал Д.Ганзориг дарга, олон улсын хэмжээний мастер, ахлах дэслэгч Н.Ууганцэцэг (311) захирагчтай ЗХЖШ-ын тасаг 0:27:01.15 амжилтаар, дэд байрт бригадын генерал П.Жаргалан захирал, цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч П.Ганзаяа захирагчтай ҮБХИС-ийн тасаг 0:30:56.52 амжилтаар, гутгаар байрт хурандаа П.Батбаатар захирал, дэслэгч Г.Чимэгсүрэн захирагчтай ДХИС-ийн тасаг 0:32:57.03 амжилтаар тус тус шалгарлаа.



### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
20	2

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,128.00	3,134.0
EUR	3,322.0	3,330.0
CNY	467.00	469.00
RUB	47.90	48.50
JPY	24.30	24.70
KRW	2.46	2.49

### ЗУРХАЙ



2022.05.25 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 25

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Нүд бүрэлдэн улцайна  
Наран ургах, шингэх:  
05.03-20.35

**Барилдлага:**

Рашаан

**Шүтэн барилдлага:**

Авахуй

**Суудал:** Мод

Энэ өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 529,040,192

Эдгэрсэн

Нийт: 499,570,087

Нас барсан

Нийт: 6,303,862

Цахим шууданд

**СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН, БЭЛТГЭЛ ХУРАНДАА Ц.ГАЛБАДРАХАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ**



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх зарлиг гарган эрхэлсэн ажил, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гарган, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж буй нэр бүхий хүмүүст төрийн дээд цол, одон, медаль хүртээсэн билээ. Тэдний нэг бол Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртсэн Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн Төрийн торгон сүргийн агын даамал, бэлтгэл хурандаа Ц.Галбадрах юм. Тэгвэл Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Соёлын гавьяат зүтгэлтэн, бэлтгэл хурандаа Ц.Галбадрахад хүндэтгэл үзүүлэн баяр хүргэлээ.

Энэ үеэр сайд Г.Сайханбаяр хэлэхдээ "Батлан хамгаалах яамны журмын дагуу төрийн өндөр



цол хүртсэн эрхмүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлдэг журамтай. Үүний дагуу Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртсэн бэлтгэл хурандаа Ц.Галбадрах танд хүндэтгэл үзүүлж байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчиндээ олон жил үр бүтээлтэй ажиллаж, түүнчлэн хурдан морины спортыг хөгжүүлэх, баяр

наадмыг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулсанд тань хувиасаа болон сайдын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс талархал илэрхийлж, Соёлын гавьяат зүтгэлтэн цолоор шагнагдсанд баяр хүргэж, аз жаргал эрүүл энхийг хүсэн ерөөе" хэмээгээд дурсгалын зүйл гардуулав.

**МУЗЕЙН ХАМТ ОЛОН НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН ТАНХИМЫН ЭРДЭМТЭН БАГШ НАРТАЙ ХАМТРАН МОД ТАРИВ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож байна. Энэ хүрээнд олон төрлийн ажлуудыг зохион байгуулж байгаа бөгөөд тус ажилд Монгол Цэргийн музейн хамт олон нэгдэж байна.

Тодруулбал, Монгол Цэргийн музейн хамт олон ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн нийгэм хүмүүнлэгийн танхимын эрдэмтэн багш ажилтан алба хаагчидтай хамтран цэргийн улс төрийн байгууллагын 101 жил, нийгэм хүмүүнлэгийн танхимийн 55 жил, дээд

боловсролтой улс төрийн ажилтан-офицер бэлтгэж эхэлсний 50 жилийн ойг тохиолдуулан 20 ширхэг улиас модыг байгууллагынхаа өмнөх талбайд тарилаа.

Энэ нь байгууллага бүр гаднах талбайгаа моджуулах, эко орчин бүрдүүлэх гэсэн Батлан хамгаалахын сайдаас өгсөн үүргийн нэг хэрэгжилт болсон бүтээлч ажлын нэг болж буй юм. Мод тарих арга хэмжээний үеэр Монгол Цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн нийгэм хүмүүнлэгийн танхимын ахмад багш доктор, дэд профессор Б.Дуламсүрэнд хүндэтгэл үзүүлээ.

Ташрамд, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбар олон төсөл хэрэгжүүлж буйн нэг нь анги, байгууллагын өнгө үзэмжийг дээшлүүлэх, эрүүл ногоон орчныг байгуулах зорилгоор Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбаруудын нийт 50 байрлалд 2022 оноос 2030 он хүртэл 800.000 мод бут, сөөг тарьж ургуулах юм.

**БАРИЛГАЧИН ДАЙЧИД "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ**



Зэвсэгт хүчний 017 дугаар анги нь цаашид бургас 20000, улиас 20000, шар хуйс 20 кг, буйлс 30 кг-ыг тарихаар төлөвлөсөн байна.

Түүнчлэн мод тарих ажлыг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхээс гадна хамт олны гар нийлэмжтэй ажиллагаа, нөхөрсөг уур

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож, 2030 он гэхэд 27 сая мод тарьж ургуулан ногоон орчныг бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Дээрх зорилтын хүрээнд Барилга-инженерийн цэргийн удирдах газрын болон Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн бие бүрэлдэхүүн энэ сарын сарын 21-ний өдөр Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Бургалтайн гол дахь тус ангийн "Мод үржүүлгийн газар"-т мод, нарийн ногоо тарих ажлыг хамтран зохион байгууллаа.

Мод үржүүлгийн газарт өнөөдрийн байдлаар бургас



50000 ширхгийг суулгацаар, гацуур 1 кг (15000), шинэс 6 кг (80000), буйлс 6 кг (5000)-ыг тус тус үрээр тарьж, арчлан хамгаалж байна.

амьсгалыг бүрдүүлэх, төмс, хүнсний ногоог хямдралтай үнээр алба хаагчдад олгож ар гэрийг нь дэмжих зорилгоор зохион байгуулж байгаа юм.

**ИХ ЯЛАЛТЫН СЭДВЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙВ**



Агуу их Эх орны дайны ялалтын 77 жилийн ойд зориулсан "Их ялалтын үнэ цэнэ" сэдэвт дугуй ширээний хэлэлцүүлэг Монгол цэргийн музейд боллоо. "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" ТББ, Ахмад дайчдын "Улаан одхон" сонины зөвлөл хамтран зохион байгуулсан уг хэлэлцүүлгээр 1941-1945 оны Эх орны дайны ялалтын ач холбогдол, фашизмын эсрэг тэмцэлд Монголын ард түмний оруулсан хувь нэмрийн талаар эрдэмтэн судлаачид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицерууд санал солилцсон юм.

Хэлэлцүүлэгт ОХУ-ын Буриад улсын Батлан хамгаалах туслах

нийгэмлэгийн тэргүүн Шагаев А.Э, тус нийгэмлэгийн дэд дарга, бэлтгэл дэд хурандаа Ефремов В.В нар оролцож ОХУ-д их ялалтын ойг хэрхэн тэмдэглэж ирсэн болон өөрийн байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Дугуй ширээний хэлэлцүүлэгт доктор, дэд профессор Лха.Баяр "Эх орны дайны жилүүд Монголын ард түмнээс Улаан армид үзүүлсэн тусламж", дэд профессор, чөлөөнд байгаа дэд хурандаа М.Бямбаргачаа "Монгол цэргийн музейн сан хөмрөгт байгаа Эх орны дайны түүхтэй холбоотой эд өлгийн зүйлс", бэлтгэл дэд хурандаа С.Өлзийдүүрэн "Монгол улс Агуу их Эх орны дайнд" номыг

орчуулах явцад ажиглагдсан зүйлс, дүгнэлт", бэлтгэл хурандаа Г.Нямдорж "Фронт Цэгмидийн ажил, амьдралын зарим онцлог" зэрэг сэдвээр ярилаа.

Хэлэлцүүлгийн үеэр үг хэлсэн ихэнх хүмүүс өнгөрсөн дайны түүх түүхээрээ үлдэх ёстой, өнөөдрийн цаг үеэс үнэлэлт дүгнэлт өгөх, үзэл сурталчлах шаардлагагүй гэдэгтэй санал нэг байв. Ялалтын тухай ярилцлага өрнөсөн хэлэлцүүлэгт Соёлын тэргүүний ажилтан, цагдаагийн дэд хурандаа Б.Алтанзул оролцож Ардын уран зохиолч Шаравын Сүрэнжавын "Ерэн баатрын дууль" найраглалыг уншиж хүмүүсийн сэтгэлийн галыг өрдөв.

**НАСАНД ХҮРЭГЧДИЙН ҮНЭМЛЭХҮЙ ЖИНД АМЖИЛ ҮЗҮҮЛЭВ**



Зэвсэгт хүчний төлөөлөл болж "Монголын Шинкиокушинкай Каратэгийн Холбоо"-ны 2022 оны "Улсын аварга шалгаруулах бүтэн контакттай тэмцээн"-ний насанд хүрэгчдийн үнэмлэхүй жинд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн "Гардан тулааны сургагч багш" тамирчин ахлагч Г.Бат-Ирээдүй оролцож гуравдугаар байрт шалгаран хүрэл медаль хүртлээ.

Одоогийн байдлаар ахлагч Г.Бат-Ирээдүй нь "Азийн холимог тулаан"-ны "One championship" холбооноос Монгол улсаас оролцох тамирчны сонгон шалгаруулалтад оролцсон 400 тамирчнаас шилдэг 20 тамирчинд шалгаран 3 дугаар үедээ тэнцэн дараачийн сорилдоо бэлтгэлээ хангаж байгаа юм.

**Ахлах ахлагч П.ДАРХАНБААТА**